



**ОРХОН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 19/10

Баян-Өндөр сум

**Волейболын өсвөр үеийн улсын аваргат
шалгаруулах тэмцээнд хөрөнгө
гаргах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Волейболын өсвөр үеийн 2025 оны улсын аварга шалгаруулах тэмцээн (охид)-д зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Тэмцээн зохион байгуулах, санхүүжүүлэх гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг спортын хэлтсийн дарга (Э.Лхамсүрэнбаатар), өсвөрийн шигшээ баг, боловсролын байгууллагын спортын асуудал, сургалт, дасгалжуулалт хариуцсан мэргэжилтэн (М.Сэргэлэн) нарт үүрэг болгосугай.

3. Тэмцээнд зарцуулагдах 2,100,000 (хоёр сая нэг зуун мянга) төгрөгийг зохих журмын дагуу үндэсний тэмцээн наадмын үйл ажиллагааны зардлаас гаргаж, гэрээний дагуу шилжүүлэг хийхийг ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Ж.Нямжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.ДЭЛГЭРБАЯР

Биеийн тамир, спортын газрын даргын
2025 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн
10/10 дугаар тушаалын хавсралт

ВОЛЕЙБОЛЫН УЛСЫН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН (ОХИД)-ИЙ ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Хоног	Хүний тоо	Шагналын дүн	Бүгд дүн (төгрөгөөр)
1	Байрны зардал	6	14	25,000	2,100,000
	Төсвийн нийт дүн				2,100,000

----oOo----

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2025 оны 02 сарын 12

Дугаар... 109

Баян-Өндөр сум

Нэг.Нийтлэг үндэслэл:

1.1.Энэхүү гэрээний зорилго нь нэг талаас Орхон аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга Д.Дэлгэрбаяр (цаашид "захиалагч" гэнэ), нөгөө талаас Орхон аймгийн "Волейболын холбоо"-ны тэргүүн П.Баясгалан (цаашид "гүйцэтгэгч" гэнэ) нар харилцан тохиролцож, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг үндэслэн, Биеийн тамир, спортын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн А/10 дугаар тушаалаар батлагдсан "Волейболын өсвөр үеийн" улсын аварга шалгаруулах тэмцээн"-д оролцох, тэмцээний төсвийг захиалагч санхүүжүүлэхэд хамтран ажиллахад оршино.

1.1.1.Захиалагч талаас (Орхон аймгийн Биеийн тамир, спортын газар) "Волейболын өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн"-ий төсвийг зарцуулах ажлыг гүйцэтгэгчид даалгаж, гүйцэтгэгч биелүүлэх үүргийг хүлээнэ.

1.1.2.Гүйцэтгэгч тал нь (Орхон аймгийн Волейболын холбоо) гэрээгээр гүйцэтгэх ажлыг (чанарын шаардлага хангасан) заасан хугацаанд багтаан Захиалагчид хүлээлгэн өгч, үнэлгээ хийж гэрээний акт үйлдсэнээр дуусгавар болно.

Хоёр.Талуудын эрх, үүрэг:

2.1.Захиалагч тал дараах эрх, үүрэг хүлээнэ.

2.1.1."Волейболын өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн"-ий төсвийн санхүүжилтийг гэрээнд заасан хугацаанд саадгүй шилжүүлэх;

2.1.2.Тэмцээний гүйцэтгэлийн явцад хяналт тавих;

2.1.3.Тэмцээний үр дүнгийн тайлан, судалгааг авах;

2.1.4.Тэмцээний санхүүжилтийн тооцоог хүлээн авч, гэрээний акт үйлдэх;

2.1.5.Шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн "Аудит" оруулан шалгалт хийлгэх;

2.1.6.Тэмцээний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээллэх ажлыг зохион байгуулах;

2.1.Гүйцэтгэгч дараах эрх, үүрэг хүлээнэ.

2.1.1.Волейболын өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд удирдамжийн дагуу оролцох, амжилт үзүүлэх;

2.1.2.Тэмцээний үеийн аюулгүй ажиллагааг хангаж, тамирчдад ХАБЗ өгсөн байх, хариуцах;

2.1.3.Тэмцээний үр дүнгийн тайлан, мэдээллийг гаргах;

2.1.4.Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, баримтыг хүлээлгэн өгөх;

2.1.5.Ажил үйлчилгээний санхүүжилтийг зарцуулахдаа нэмэгдсэн өртгийн албан татварыг тооцож, үйл ажиллагааны зардлыг зарцуулах;

2.1.6.Тайланг тэмцээн дууссаны дараа ажлын 5 хоногт багтаан хүлээлгэн өгөх;

Гурав.Санхүүжилт:

3.1.Төсвийн санхүүжилт 2,100,000 (хоёр сая нэг зуун мянга) төгрөг байна.

3.2.Санхүүжилтийг Орхон аймгийн **“Волейболын холбоо”-ны Голомт** банкны 4005005729 тоот дансанд төрийн сангийн санхүүжилт хийгдсэний дараа ажлын 3 хоногт шилжүүлнэ. (байгууллагын регистр 8065365)

3.3.Гэрээгээр гүйцэтгэхэд шаардагдах зардлын задаргаа нь гэрээний салшгүй хэсэг байна.

Дөрөв. Бусад:

4.1.Гэрээг адил хүчинтэй 2 хувь үйлдэнэ, тэмцээний төсвийн задаргаа нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

4.2.Гэрээг байгуулах болон хэрэгжүүлэх бүхий л үе шатуудад талууд ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөн, ашиг сонирхлын аливаа зөрчил гаргахгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллана;

4.3.Талууд харилцан нэмэлт өөрчлөлт оруулахдаа гэрээ байгуулсан зарчмаар шийдвэрлэх ба нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.4.Талууд гарын үсэг зурснаар энэхүү гэрээ хүчин төгөлдөр болно.

ЗАХИАЛАГЧ:
ОРХОН АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ДЭЛГЭРБАЯР



2025.02./ /

Утас: 99369834

АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ:
“ОРХОН АЙМГИЙН ВОЛЕЙБОЛ”-НЫ
ХОЛБООНЫ ТЭРГҮҮН
П.БАЯСГАЛАН



2025.02./ /

Утас: 99351475

СПОРТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Э.ЛХАМСҮРЭНБААТАР

Утас: 99556765

ГЭРЭЭГ ХАРИУЦАГЧ АЖИЛТАН

НАРИЙН БИЧИГ

С.СОНИНБИЛЭГ

Утас: 99351761

МЭРГЭЖИЛТЭН

М.СЭРГЭЛЭН

Утас: 99747814

Утас: 95364656

ВОЛЕЙБОЛЫН ОХИДЫН УЛСЫН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

	Зардлын нэр	Хоног	Хүний тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд (төгрөгөөр)
1	Байрны зардал	6 хоног	14	25,000	2,100,000
Дүн				2,100,000	

---oOo---